Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн "Журам батлах тухай " 25 дугаар тогтоолын хавсралт" Боловсролын байгууллагын үйл ажиллагааны олон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай" 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн "Тогтоолд хавсралт нэмэх,тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт, шинжилгээ, дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,035.7 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 58,884.7 | 165,467.9 | 106,583.2 |
| Авлага | 136.3 | | 136.3 |
| Бараа материал | 136,733.0 | 144,024.3 | 7,291.3 |
| Үндсэн хөрөнгө | 5,016,959.3 | 5,112,140.6 | 95,181.3 |
| Хуримтлагдсан элэгдэл | -559,848.6 | -669,732.4 | -109,883.8 |
| **Нийт хөрөнгө** | **4,652,864.7** | **4,751,900.4** | 99,035.7 |
| Өр төлбөр | | 78,834.6 | 78,834.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **4,652,864.7** | **4,673,065.8** | 20,201.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,652,864.7** | **4,751,900.4** | 99,035.7 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны үзүүлэлтээс нилээ бухий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, мөнгөн хөрөнгө ,үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 58,884.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 165,467.9 мянган төгрөг өмнөх оноос 106,583.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотойгоор хүүхдийн тооноос хамаарч төсөв батлагдсан ба гүйцэтгэлээр зарцуулагдсан төсвөөс хэмнэлт үүссэн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 124,432.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, бараа материалын үлдэгдэл 7,291.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 89,726.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 55,613.1 мянган төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмж, 45,777.9 мянган төгрөгийг тавилга хэрэгслийн дансдад үндсэн хөрөнгийн орлогоор бүртгэн 95,181., мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж Аймгийн ИТХ-ын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Хөрөнгө актлаж данснаас хасах тухай” 38 дугаар захирамжаар 68,846.9 мянган төгрөгийн барилга, 6,016.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 21,074.9 мянган төгрөгийн тавилга хэрэгслэл актлах шийдвэр гарч данснаас хассан байна.

Тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу төлөлт 16,141.2 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 669.7 мянган төгрөг , Монголын цахилгаан холбоотой байгуулсан гэрээгээр интернетийн дотоод



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДУГИЗЛТ

сүлжээ, цахим ангийн тоног төхөөрөмж худалдан авснаас 61,612.2 мянган төгрөг нийт 78,834.6 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 20,201.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 4,673.065.8 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 20,201.1 мянган төгрөг, богино хугацаат өр төлбөр 78,834.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 4,751,900.4 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,691,812.8 мянга, орон нутгаас авах санхүүжилтийг 166,846.0 мянган төгрөг нийт санхүүжилт 1,858,658.8 мянган төгрөгөөр тодотгож ирүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,632,789.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 58,884.7 мянга, үйл ажиллагааны орлогоос 440.0 мянга, орон нутгийн төсвөөс 166,846.0 мянган төгрөг нийт 1,858,959.8 мянган төгрөгийн эх үүсвэртэй гүйцэтгэлээр 1,691,942.5 мянган төгрөгийг зарцуулж, 165,467.9 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 166,846.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99 хувь буюу 165,296.5 мянган төгрөгийг зарцуулсан.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 2,491.9 | 2,491.3 | 0.6 | 99.9% |
| 2 | 80233 Хүүхэд хамгаалал | 2,554.7 | 2,555.6 | 0.9 | 100% |
| 3 | 80312 Сургалт семинар | 1,739.8 | 1,732.6 | 7.2 | 99.5% |
| 4 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 2,493.9 | 2,493.0 | 0.9 | 100% |
| 5 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 50,422.3 | 47,282.3 | 3,140.0 | 93.7% |
| 6 | 81806 Дотуур байр | 261,001.4 | 183,778.9 | 77,222.5 | 70.9% |
| 7 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 38,351.3 | 38,351.6 | -0.3 | 100% |
| 8 | 81823 Боловсролын байгууллагын багш | 7,477.5 | 7,476.5 | 0.9 | 100% |
| 9 | 81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 14,368.7 | 10,184.7 | 4,184.0 | 70.8% |
| 10 | 81834 Боловсролын стандарт, сургалтын | 1,232,948.4 | 1,154,720.4 | 78,228.0 | 93.7% |
| 11 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 73,916.3 | 71,534.3 | 2,382.0 | 96.7% |
| 12 | 81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр | 3,904.8 | 3,904.5 | 0,3 | 100% |
| 13 | 81844 Гүнгэгийрүүлсэн болон төрөлж | 140.0 | 140.0 | 0.0 | 100% |
| 14 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 166,846.0 | 165,296.5 | 1,549.5 | 99.0% |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | 2023 оны харицахын үлдэгдэлээс | | | 51,235.9 | |
| ДҮН | | 1,857,410.4 | 1,691,942.5 | 165,467.9 | 91.9% |

Эх сурвалж:2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О.Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын менежер М.Алтантуяа, Баянхонгор аймгийн газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Д.Цэцгээ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Шүрсайхан 2024 оны 05 дугаар сарын 10 хүртэл, нягтлан бодогч (ажил хавсран гүйцэтгэсэн) Б.Өлзиймаа 2024 оны 11 дүгээр сарын 14 хүртэл, Д.Буян-Өлзий 2024 оны 11 дүгээр сарын 15 томилогдон ажилласан, нярваар Н.Эрдэнэтуяа, Б.Мөнхзул нар ажиллажээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны анхны батлагдсан төсөв 1,894,804.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,948.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15,158.4 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,241,084.1 мянган төгрөгийн 40 гүйлгээ, зарлагын 211,330.1 мянган төгрөгийн 19 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 5 | 5 | 4 | 1 | 0 |
| 4 | Сар бүр | 2 | 24 | 24 | 0 | |
| 5 | Тухай бүр | 7 | 84 | 84 | 0 | |
| | Нийт | 14 | 113 | 112 | 1 | 0 |

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

### 4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Тус сургууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үнэлгээний хороог захирлын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/05 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдхүүнтэй томилж дотуур байрны хүүхдийн хоол 64,537.2 мянга, үдийн хоолны 47,644.2 мянган төгрөгийн материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерыг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрөөс 03 дугаар сарын 13-ний өдрийг хүртэл ажлын 5 хоногт багтан худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-;-д тендерийн бичиг баримтыг байршуулсан байна.

Үдийн хоолны материал нийлүүлэх тендерт 45,823.6 мянган төгрөгөөр тендерт "Цахир хайрханы хишиг" ХХК, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт 51,651.5 мянган төгрөгөөр тендерт "Түүх ноён Хайрхан" ХХК бараа материал нийлүүлэх гэрээг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны тендер зарлах хугацаа хүртэл байгуулан ажилласан байна. Худалдан авах гэрээний үнийн дүнг мөрдөн ажиллаж гэрээг дүгнэн ажилласан байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Номгон аудит ХХК -ний аудитын баг гүйцэтгэж "Зөрчил арилгуулах тухай" нэг албан шаардлага, төлбөр барагдуулах тухай 2 акт хүргүүлэн 2024 оны 06 дугаар сарын 12 өдрийн 58 тоот албан бичгээр гүйцэтгэлийг ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **2** | 2,268.0 | **2** | **2,268.0** | **100** |
| Албан шаардлага | 1 | 26,328.0 | 1 | 26,328.0 | 100 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **3** | 28,596.0 | **3** | 28,596.0 | 100 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын урамшууллыг олгохдоо "Өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэн болович төлбөрийг акт тогтоосон байхад нягтлан бодогч үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тушаал гарган олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,375.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 төлбөрийн акт тогтоов.

### 5.1.1 Төлбөрийн акт

Гурванбулаг сумын ЕБС-ийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16 өдрийн " Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай" Б/61 тоот тушаалаар нягтлан бодогчоор хавсран ажиллаж байсан Б.Өлзиймаад 45%, 2024.11.14-ны өдөр томилогдсон нягтлан бодогч Д.Буян-Өлзийд 22%, нярав Б.Мөнхзул 27%, нарт 2024 оны 4 дүгээр улирлын мөнгөн урамшуулал 1,015.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Төсвийн шууд захирагчаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 5.1.2 **Төлбөрийн акт**

Гурванбулаг сумын ЕБС-ийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16 өдрийн "Датаны зардал зарцуулах тухай" Б/68 тоот тушаалаар 2024 оны 4 улирлын дата хэрэглээний зардал нэг хүнд 45.0 мянган төгрөгөөр тооцож захирал, сургалтын менежерүүд, нягтлан бодогч, нярав, эмч, номын санч, архив бичиг хэргийн ажилтан нийт 8 ажилтанд олгосон байна.

Энэ нь Боловсрол, шинэлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 2.4 дэх "... үндсэн багш..." заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" зэрэгийг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн шууд захирагч нягтлан бодогчоор төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | |
|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | То о | Дүн | То о | Дүн | Т о о | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Гурванбулаг сумын ЕБС-ийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16 өдрийн " Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай" Б/61 тоот тушаалаар зарим ажилтанд мөнгөн урамшуулал олгосон ньТөсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 (Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах), 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт (төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)-ын заалтуудтай нийцэхгүй байна | 1 | 1,015.0 | 1 | 1,015.0 | | | | |
| Гурванбулаг сумын ЕБС-ийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16 өдрийн " Датаны зардал зарцуулах тухай" Б/68 тоот тушаалаар 2024 оны 4 улирлын дата хэрэглээний зардал нэг хүнд 45.0 тооцож 8 ажилтанд олгосон нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 2.4 дэх "(.. үндсэн багш..) заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 (Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах), 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах) зэрэг хууль журамын заалтуудтай нийцэхгүй байна. | 1 | 360.0 | 1 | 360.0 | | | | |
| Нийт дүн | 2 | 1,375.0 | 2 | 1,375.0 | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--оОо---



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 25 өдөр    Дугаар 52/14210513/БНА-2025/004/НА-СТА-ТШЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гурванбулаг сумын сургуулийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16 өдрийн "Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай" Б/61 дугаар тушаалаар нягтлан бодогчоор хавсран ажиллаж байсан Б.Өлзиймаад 45 хувь, 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр томилогдсон нягтлан бодогч Д.Буян-Өлзийд 22 хувь, нярав Б.Мөнхзулд 27 хувиар үндсэн цалингаас тооцож 4 дүгээр улирлын мөнгөн урамшуулалд нийт 1,015,052.00 / нэг сая арван таван мянга тавин хоёр/ төгрөгийг зориулалт бусаар олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын заалтуудыг зөрчиж "Эрх ба үүрэг" "Үнэн ба зөв байх" батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050104

1.Зориулалт бусаар олгосон урамшуулал 1,015,052.00 / нэг сая арван таван мянга тавин хоёр/ төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлэх төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Цэцгээ, нягтлан бодогч Д.Буян-Өлзий нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ, АУДИТОР: Г.САРАНЧИМЭГ

6417143544
БЮА0067 9007423

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 531/14210573/БНА-2025/004/ НА-СМА-ТАШЗ. Номгон

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гурванбулаг сумын сургуулийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн " Датаны зардал зарцуулах тухай" Б/68 дугаар тушаалаар 2024 оны 4 улирлын дата хэрэглээний зардал нэг хүнд 45000 төгрөгөөр тооцож захирал, сургалтын менежерүүд, нягтлан бодогч, нярав, эмч, номын санч, архив бичиг хэргийн ажилтан нийт 8 ажилтанд 360,0000 /гурван зуун жаран мянган/ төгрөг олгосон байна.

Энэ нь Боловсрол, шинэлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 2.4 дэх ".. үндсэн багш.." заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" зэрэг заалтуудыг зөрчиж "Эрх ба үүрэг" "Үнэн ба зөв байх" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050106

1.Зориулалт бусаар олгосон дата багцын үнэ 360,000 /гурван зуун жаран мянган/ төгрөгийг төсвийн шууд захирагчаар төлүүлэх төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Цэцгээ, нягтлан бодогч Д.Буян-Өлзий нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ, АУДИТОР: Г.САРАНЧИМЭГ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно